

**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН 2021 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжилт	
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэрээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.	Авлигатай тэмцэх газраас бэлгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), болон лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх	- Баримтжуулж, үр дүнг тооцож тайлагнасан байх	Жилдээ	Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах чиглэлээр Авлигатай тэмцэх газраас бэлгэсэн авлигын эсрэг сурталчилгааг видео болон зурагт хуудас, нугалбар зэрэг мэдээлийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мөн байгууллагын олон нийтийн сүлжээ /фэйсбүүк/-гээр дамжуулан авлигын эсрэг үйл ажиллагаа сурталчилсан. 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн самбарт Авлигатай тэмцэх газраас бэлгэсэн контент, зурагт хуудас, нугалбар зэрэг мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэн ажилласан.
		1.2.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар, нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	- Дэмжиж хамтран ажилласан байх - Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх	Жилдээ	Авлигатай тэмцэх газраас олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2021 оноос эхлэн “Зөв зөвд шударга зөв” аян болон тайлант онд “GOOD HABITS-20” буюу “Зөв дадал-20” аяныг дэмжин байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээ/ /фэйсбүүк/-гээр түгээсэн.

						Эгэл ардын зарлиг, Шударга үнэн Гэрэл тусгая! Шударгай зөв бай! Авлигын шилэн бөмбөлөг шторк Авлигын цаана Зөвд шударга Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах вэ? Зэрэг шторк хэвлэмэл хуудсыг байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулж дэмжлэг үзүүлэн ажилласан.
		1.2.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	- Мэдээллийг тогтмол шинчлэх ажлыг хэвшүүлсэн байх, - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	Жилдээ	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг байгууллагын үүдэнд байршуулан мэдээллийг шинэчлэн ажилласан.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1.	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлэх	- Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	1 дүгээр сард	Тус газар 2021 онд Газрын харилцаа, хот байгуулалтын шинэтгэл сэдвийн хүрээнд улсын хэмжээний үндэсний форум хийхээр төлөвлөсөн бөгөөд дээрх форумд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд, сумын газрын даамал, Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны нийт 1000 гаруй албан хаагчид оролцохоор төлөвлөсөн бөгөөд сургалтын захиалгыг Авлигатай тэмцэх газрын

						Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст тус газрын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1/205 тоот албан бичгээр хүргүүлсэн.
		2.2.	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Төлөвлөгөөнд туссан хугацаанд	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ЭБАТ-уудад зориулж 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн цахим сургалтад ЭБАТ болон орон нутгийн ЭБАТ-ын идэвхитэй хамруулсан. 2021 оны 04 дүгээр сарын сүүлээр Газрын харилцаа, хот байгуулалтын шинэтгэл сэдвийн хүрээнд улсын хэмжээний үндэсний форумыг зохион байгуулж, форумд оролцогчдод “Авлигын эсрэг” сэдэвт сургалт авахаар төлөвлөж байсан боловч дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдварыг нөхцөл байдлаас шалтгаалан зохион байгуулах боломжгүй болсон. “Газрын харилцааны салбарын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран анхан шатны сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд аймгийн ГХБХБГ болон НГЗБА-ны 200 гаруй албан хаагчид оролцсон.
		2.3.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар	- Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх	Жилдээ	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

			дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж үр дүн тооцож, тайлагнах	- Хамрагдсан хүүхэд залуус, иргэдийн тоо		сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар Авлигатай тэмцэх газрын УССГХ-ийн ажилтан Ж.Сарангэрэлтэй хамтран Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Дарга, Нэгжийн дарга, Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд зориулсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 60 гаруй албан хаагч хамрагдсан.
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмээг хэрэгжүүлэх	- Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Тухай бүр	2021 оны жилийн эцсийн байдлаар тус газарт нийт Авлигатай тэмцэх газар болон шүүхээс 429 албан бичиг, тогтоол, захирамж 60 иргэний өргөдөл ирсэн байна. Үүнээс: 374 нотлох баримт, 26 шинжээчийн дүгнэлтийг гарган албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлсэн. 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 7 шинжээчийн дүгнэлт хэмжилт, зураглалын ажил хийгдэж, 9 шинжээчийн дүгнэлт, 13 нотлох баримт хүссэн албан бичиг хянагдаж байна. Мөн иргэний 60 өргөдлийг судалж, хугацаанд нь шийдвэрлэж, албан бичгээр хариуг хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас Шинжээчийн дүгнэлт гаргах мөрдөгчийн тогтоолын дагуу ажлын хэсгийг байгуулан, дүгнэлт гаргуулах 63 албан тоот ирсэнийг судлан

						нотлох баримт болон шинжээчийн дүгнэлт хүргүүлэх 93 албан тоотын заасан хугацаанд гарган хүргүүлэн ажиллаж байна.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл санаачилга өрнүүлэх	4.1.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга, уриа, аянд нэгдэж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах	- Тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	Жилдээ	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга, уриа, аянд нэгдэж байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээ/ /фэйсбүүк/-гээр түгээсэн.
		4.2.	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах		Жилдээ	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсэгт Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо, Газар зохион байгуулагчдын холбооноос төлөөлөл оролцуулан хурлыг зохион байгуулдаг бөгөөд 2021 оноос эхлэн тусгай зөвшөөрлийн материалыг цахим системээр дамжуулан авч эхэлсэн.
уха	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга	5.1.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	- Шинэ шийдэл технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион	Жилдээ	Тус газар нь газрын харилцааны талаарх төрийн бодлогын нэгдмэл байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хүрээнд Газрын харилцааны шинэтгэлийг хэрэгжүүлж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах, хөрөнгө

хэмжээ авах			байгуулсан байх		<p>оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи дээр суурилан шинэчлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх ажлуудыг хийж хэрэгжүүлэн “Газрын удирдлагын нэгдсэн цахим систем”-ийг бий болгож улсын хэмжээнд нэвтрүүлэн “ХУР”, “ДАН” системтэй холбож хэрэглээнд нэвтрүүлэн Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор албажуулсан.</p> <p>“Газрын удирдлагын нэгдсэн цахим систем”-д Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн, Газрын кадастрын, Газрын цахим биржийн, Газрын үнэлгээ, төлбөр, татварын цахим систем, Газрын мониторингийн сүлжээ, Байрлалд суурилсан хаягийн нэгдсэн сан, Хот байгуулалтын кадастрын цахим системүүд багтсан бөгөөд төлөвлөгөөнд иргэд олон нийтээд санал авч, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд газар олгох ажлыг зохион байгуулахад албан тушаалтны нөлөөг багасгаж бууруулах зорилготой ажиллаж байна.</p>
	5.2	Орон зайн суурь 16 төрлийн өгөгдөл солилцох “Нэг газрын зураг”, “Нээлттэй газрын зураг” үйлчилгээг нэвтрүүлэх	- Цахим хэлбэрт шилжсэн байх	Жилдээ	<p>Дэлхийн банкны Монгол улстай түншлэх 2021-2025 оны стратегийн төслийн баримт бичигт орон зайн мэдээллийн менежментийн чиглэлээр санал тусгуулах ажлыг БХБЯ-тай хамтран зохион байгуулж, холбогдох мэдээллээр ханган ажилласан.</p> <p>2021.03.15-нд газрын даргын</p>

					<p>дэргэдэх зөвлөлийн хурлаар НҮБ, Дэлхийн банкны Зөвлөх багтай хамтран боловсруулсан Монгол Улсын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн судалгааны үр дүн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэв.</p> <p>Мөн “Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах арга хэмжээний төлөвлөгөө”, “Орон зайн суурь 18 өгөгдлийн хүрээ”-г боловсруулж, 2021.05.11-нд зохион байгуулагдсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 5 дугаар хурлаар хэлэлцүүлж батлуулав. Орон зайн өгөгдлийн сангуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Монгол Улсын Шадар сайдын ахалсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны V хурлаар батлуулсан орон зайн суурь өгөгдлийн хүрээний дагуу MNS 6925 1-18:2021 газар зүйн мэдээллийн багц стандартын дагуу хөрвүүлж, нийтийн хэрэглээнд гарахад бэлэн болсон.</p> <p>“Орон зайн өгөгдөл, мэдээллийг нэг эх сурвалжаас ашиглах тухай”, “Орон зайн өгөгдөл, мэдээлэл солилцох зориулалт бүхий Геопорталыг улсын хэмжээнд нэвтрүүлэх тухай” Монгол Улсын</p>
--	--	--	--	--	--

						Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт бэлтгэж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулсан.
		5.3	Салбарын тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрх олгох үйл ажиллагааг цахимжуулах	- Цахим хэлбэрт шилжсэн байх	Жилдээ	<p>Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох материалыг цахим системээр дамжуулан авч эхэлсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар цахим системээр геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахаар нийт 75 хүсэлт ирсэн. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр олгосон 49 - Сунгасан 17 - Ажлын хэсэгт шилжүүлсэн 5 - Суурь нөхцөл шаардлага хангаагүй материал ирүүлээд буцаагдсан 9 - Ажлын хэсгээс татгалзсан дүгнэлт гаргасан 2 хуулийн этгээдийн хүсэлт байна. <p>Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн албан ёсоор цахим</p>


					<p>(https://license.gazar.gov.mn/) хэлбэрт шилжүүлсэн. 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тус системд мэргэжлийн байгууллагын эрх шинээр авахаар 28 хуулийн этгээдээс 80 хүсэлт, эрхээ сунгуулахаар 20 хуулийн этгээдээс 25 хүсэлт, нийт 48 хуулийн этгээдээс 105 хүсэлт ирсэн бөгөөд ирүүлсэн хүсэлтүүдийг судалж холбогдох арга хэмжээг зохион байгуулсан. Ирүүлсэн хүсэлтийг төлвөөр нь задалж үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Олгосон /Шинээр олгосон болон сунгасан/ 45; - Зөвшөөрсөн /Ажлын хэсгээс дэмжигдсэн/ 12; - Татгалзсан /Ажлын хэсгээс дэмжигдээгүй/ 13; - Буцаагдсан /Суурь нөхцөл шаардлага хангаагүй/ 33; - Хянагдаж байгаа 2 хүсэлт байна. <p>Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах Ажлын хэсэг танхимаар 1 удаа, цахимаар 8 удаа хуралдаж, Барилга, хот байгуулалтын Сайдын тушаалаар 28 хуулийн этгээдэд мэргэжлийн байгууллагын эрх шинээр олгож, 12 хуулийн этгээдийн мэргэжлийн байгууллагын эрхийг сунгасан. Сайдын тушаалын дагуу</p>
--	--	--	--	--	---

					гэрээ, гэрчилгээг хэвлэж албажуулан хуулийн этгээдэд тухай бүрт нь олгосон.	
		5.4	Бүх шатны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ирүүлсэн иргэд олон нийтийн саналд анализ хийж хариу өгөх модулыг хөгжүүлэх	- Цахим хэлбэрт шилжсэн байх	Жилдээ	Байгууллагын цахим хуудас болох egazar.gov.mn хаягаар дамжуулах иргэдээс 11 төрлийн санал авах, ирүүлсэн саналуудыг төрлөөр ялгаж тайлан гаргах, дэлгэрэнгүй жагсаалт гаргах анализ хийх боломж бүхий системийн хөгжүүлэлтийг хийж 2021 оны 8 сард хэрэглээнд нэвтрүүлсэн.
		5.5	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн програм хангамжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх	- Цахим хэлбэрт шилжсэн байх	Жилдээ	БХБ-ын Сайдын 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн “Тушаалын хэрэгжилтийг хангуулах тухай” “Монголын барилгын үндэсний ассоциаци”-д хүргүүлсэн 1/3694 дугаар албан бичгийн дагуу “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл аж, ахуйн нэгжүүдэд олгох эрх шилжүүлэх талаарх 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр болсон оролцогч талуудын цахим хурлаас Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж, ахуйн нэгжүүдийн мэдээллийг мэдээллийн сангаас цахим хэлбэрээр 2021 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр 1040 аж ахуйн нэгжийн жагсаалтыг Хот байгуулалтын хэлтэс хүлээн авсан. Барилгын хөгжлийн төв ТӨУҮГ-ын захиалгаар “Интерактив” ХХК-ийн гүйцэтгэж байгаа нэгдсэн цахим бүртгэлийн программ боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалтын

					баримт бичиг боловсруулах эрх олгогдохоор хүлээгдэж байна.	
		5.6	Геодези, зураг зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, цахим үйлчилгээ үзүүлэх	- Цахим хэлбэрт шилжсэн байх	Жилдээ	Орон зайн суурь 18 өгөгдөл, мэдээллийн өгөгдлийн санг удирдах тогтолцоог шинэчлэн зохион байгуулах, орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх системийг байгуулах ажлын хүрээнд Засаг захиргааны хил, Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн сан, Газар зүйн нэрийн мэдээллийн сан, хаягийн 1:100000-ны зураг зэргийн өгөгдлийн санд оруулан газрын удирдлагын системтэй холбох туршилтын ажлыг гүйцэтгэсэн. Газрын удирдлагын нэгдсэн систем Геопортал системүүдийн хооронд мэдээлэл дамжуулах зорилготой дундын сервер зохион байгуулж ГУНС-ээс нэгж талбар, барилга, нэгдмэл сан, хаягийн мэдээллүүдийг авах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд цахим үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг сайжруулах	6.1.	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах	- Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	жилдээ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ болон бусад шийдвэрийг Шилэн дансны тухай хууль болон журамд заасын дагуу

						<p>шилэн данс хөтлөлтийг тогтмол шинэчлэн ажилласан.</p> <p>2021 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 9 тушаал, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 137, зардал гаргасан 55 тушаалыг шилэн дансанд байршуулсан.</p> <p>-Байгууллагын батлагдсан орон тоонд ажиллаж буй албан хаагчдын мэдээллийн өөрчлөлтийг сар бүр тогтмол шинэчилсэн.</p>
	6.2	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагын 2021-2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулсан. Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн байршуулдаг.	
	6.3	Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэл, холбогдох утас, ерөөний дугаар зэрэг мэдээллийг	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэл, холбогдох утас, ерөөний дугаарыг байгууллагын	

			цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх			цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулдаг.
	6.4	Салбарын болон байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Салбарын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудасны эрх зүйн акт болон хууль, эрх зүйн буланд тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	
	6.5	Иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг байгууллагын цахим хуудасны тусгай зөвшөөрөл болон архивын үйлчилгээний буланд байршуулан ажиллаж байна.	
	6.6	Иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны иргэн хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх албан хаагчийн нэр албан тушаал, харилцах утас, цагийн хуваарь зэрэг мэдээллийг багтаасан мэдээллийн самбар байршуулан ажиллаж байна. Жишээ нь: Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар албан хаагчдыг албан тушаал хариуцсан ажил, гар утасны дугаар, өрөөний дугаар, зургийг байршуулсан нь иргэдэд ямар үйлчилгээ авахад хэн гэдэг хүнтэй уулзах талаар бүрэн	

					<p>мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн байна. Сумын даамлуудыг бүс тус бүрээр нь гаргаж байршуулан ажиллаж байна.</p> 
	6.7	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг цахимаар болон бусад хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, хариуг хугацаанд нь өгөх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	<p>Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч сканердаж ABLE програмд бүртгэн бүртгэн, газрын даргад танилцуулан холбогдох хэлтэст шилжүүлэн ажиллаж байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар нийт 3837 албан бичиг ирсэн байна.</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичгийн бүрдлийг шалгаж албан хэрэг хөтлөлтийн програм хангамж ашиглан бүртгэж, газрын даргаа</p>

						<p>цохолт хийлгэж холбогдох хэлтэст цаг алдалгүй шилжүүлэн ажиллаж байна. Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг Газрын шуурхай хуралд 7 хоног бүрд танилцуулан шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар байгууллагад нийт 240 өргөдөл гомдол ирүүлснийг 96.25 хувь шийдвэрлэн хариуг хугацаа алдалгүй хүргүүлэн ажилласан.</p> <p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг газрын шуурхай хуралдаанд 7 хоног бүр танилцуулан шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, удирдлагад танилцуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Байгууллагаас нийт 2325 албан бичгийн бүрдлийг шалгаж дугаар өгч сканердаж ABLE програм хангамжид бүртгэн холбогдох байгууллагад хугацаа алдалгүй байгууллагын хаяг, бүртгэлийн дугаарын бичилт хийж шуудангаар болон биечлэн хүргүүлсэн.</p>
		6.8	Тухайн байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхийн жагсаалт, тэдгээрийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудас болон мэдээллийн	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрд	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох материалыг цахим системээр

	самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулах			дамжуулан авч эхэлсэн бөгөөд Байгууллагын цахим хуудасны тусгай зөвшөөрөл цэсэнд дарахад тусгай зөвшөөрлийн цахим системд холбогдох бөгөөд шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмыг байршуулсан.
6.9	Тухайн зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн жагсаалтыг сар бүр шинэчлэн байршуулан ажилладаг.
6.10	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифийн талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ нь төрийн архивын үйлчилгээ, геодези, зураг зүйн багаж баталгаажуулалтын үйлчилгээ бөгөөд төрийн архивын үйлчилгээнд Архивын ерөнхий газрын даргын “Төрийн архивын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2021 оны А/24 дүгээр тушаалыг мөрдөн ажилладаг. Тус тушаалыг төрийн архив, үйлчилгээний үнэ тариф гэсэн цэсэнд байршуулсан.
6.11	Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал,	- Боломжийг бүрдүүлсэн байх	Тухай бүр	Тус газраас боловсруулан батлах, батлуулах хэм хэмжээний актуудын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийтээс санал авч ажилладаг. Мөн боловсруулсан төслийг төрийн болон төрийн бус байгууллагат албан бичгээр хүргүүлэн санал авч

		<p>шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх</p>		<p>саналыг тусган ажилладаг. Тайлант хугацаанд Орон зайн мэдээллийн суурь 18 өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлага /UML/-ийн стандартуудын төслийг Орон зайн мэдээлэл, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн ба мөн 2021 оны 05 дугаар сарын 11-нд зохион байгуулагдсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 5 дугаар хурлаар хэлэлцэж батлуулав. Хурлаас үүрэг болгосны дагуу Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн орон зайн суурь 18 дэд сангийн техникийн үзүүлэлтийн стандартын төслийг батлуулах үүрэг бүхий СХЗГ-тай хамтарсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг А/110 тоот тушаалаар баталсан.</p> <p>Ажлын хэсгийн хурлыг 2021 оны 05 дугаар сарын 24-нд зохион байгуулж, СХЗГ-аас 71 байгууллага руу 1/307, ГЗБГЗЗГ-аас санал авахаар нийт 49 байгууллагууд руу 1/1067 албан тоот бичиг тус тус хүргүүлж санал өгөх боломжийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>“Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын төсөлд 21 аймгийн ГХБХБГ болон нийслэл, дүүргийн ГЗБА-наас ирүүлсэн саналыг тусган 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж, Газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын</p>
--	--	--	--	--

				15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдаж, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 5477 дугаартайгаар захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдсэн болно.
	6.12	Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	- Тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	Тухай бүр Тус газар нь газрын харилцааны талаарх төрийн бодлогын нэгдмэл байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хүрээнд Газрын харилцааны шинэтгэлийг хэрэгжүүлж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи дээр суурилан шинэчлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх ажлуудыг хийж хэрэгжүүлэн “Газрын удирдлагын нэгдсэн цахим систем”-ийг бий болгож улсын хэмжээнд нэвтрүүлэн “ХУР”, “ДАН” системтэй холбож хэрэглээнд нэвтрүүлэн Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор албажуулсан. “Газрын удирдлагын нэгдсэн цахим систем”-д Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн, Газрын кадастрын, Газрын цахим биржийн, Газрын үнэлгээ, төлбөр, татварын цахим систем, Газрын мониторингийн сүлжээ, Байрлалд суурилсан хаягийн нэгдсэн сан, Хот байгуулалтын кадастрын цахим системүүд багтсан бөгөөд төлөвлөгөөнд иргэд олон нийтээд

					<p>санал авч, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд газар олгох ажлыг зохион байгуулахад албан тушаалтны нөлөөг багасгаж бууруулах зорилготой ажиллаж байна. Газрын үнэлгээ, төлбөр татварын системээр дамжуулан иргэд газрын төлбөрөөр гар утас болон ТҮЦ машин ашиглан төлөх боломжтой болсон.</p> <p>Мөн энэ онд Хаягийн мэдээлийн нэгдсэн системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цахим шинэчлэлийн хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-тай холбох ажлыг гүйцэтгүүлэхээр Газрын даргын 2021 оны А/177 дугаар тушаалыг үндэслэн “Софт мастер” ХХК-тай ГЗБГЗЗГ-ын 2021/205 тоот гэрээг байгуулж, 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдөр хүртэл 1 сарын хугацаанд гүйцэтгүүлсэн. Тус ажлын хүрээнд дараах лавлагаа, мэдээлэл бүхий сервис үйлчилгээг бэлтгэн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia/-д хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Кадастрын зургийн лавлагаа авах 2.Газар өмчлөх эрхийн лавлагаа авах
--	--	--	--	--	--

					<p>3.Газар эзэмших эрхийн лавлагаа 4.Газар ашиглах эрхийн лавлагаа 5.Нэгж талбарын тодорхойлолт авах 6.Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт авах 7.Газрын кадастрын мэдээллийн сангийн лавлагаа авах 8.Газар эзэмших, ашиглах гэрээний биелэлтийн лавлагаа авах 9.Газрын үнэлгээний мэдээллийн лавлагаа авах 10.Газрын төлбөр, татварын мэдээлэл, лавлагаа авах 11.Газрын дуудлага худалдааны анхны үнийн мэдээлэл авах 12.Газар эзэмших, ашиглах эрхийн барьцааны лавлагаа авах 13.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа авах 14.Газрын хувийн хэргийн материалыг нууцлал бүхий кодоор баталгаажуулан хуулбарлан авах 15.Өргөдөл хүсэлтийн лавлагаа авах зэрэг болно.</p>
	6.13	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Иргэн бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг газрын шуурхай хуралдаанд 7 хоног бүр танилцуулан шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, нэгжийн дарга нарыг мэдээллээр ханган ажиллаж байна. Газрын цахим систем буюу www.e.gazar.gov.mn болон гар утасны аппликейшнээр дамжуулан иргэн газрын зөрчил

					мэдээлэх боломж бүрдүүлсэн. Иргэн тус системд ДАН системээр нэвтэрч орон зөрчил маргааныг мэдээлэх боломж бүрдсэн байна.
	6.14	Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудсанд мэдээлж байх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	1 дүгээр сард	Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөө, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал цэсний үйл ажиллагааны ил тод байдал буланд хагас, бүтэн жилээр байршуулан ажиллаж байна.
	6.15	Байгууллагын “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г байгууллагын цахим хуудсанд мэдээлж байх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	1 дүгээр сард	Салбарын хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны арга хэмжээний төлөвлөгөө болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө шинээр боловсруулж, газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/29 тоот тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөг байгууллагын цахим хуудасны ил тод байдал цэсний авлигатай тэмцэх үйл ажиллагаа буланд байршуулан ажиллаж байна.
	6.16	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжилт, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудсанд мэдээлж байх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	1 дүгээр сард	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар гаргаж Авлигатай тэмцэх газарт тус газрын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/91 тоот албан бичгээр хүргүүлсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж 2021 оны

					08 дугаар сарын 13-ны өдрийн 1/1510 тоот албан бичгээр хүргүүлсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар гарган 2021 оны 12 дугаар сарын 15-нды өдрийн 1/2467 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	7.1	Байгууллагад гарсан сул орон тооны зарыг цахим хуудас болон холбогдох байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарлах	- Зарлал тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагын хэмжээнд гарсан сул орон тоог Төрийн албаны зөвлөл болон Төрийн албаны Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлж, байгууллагын цахим хуудасны ил тод байдал булан сул орон тоо, нээлттэй ажлын байр цэсэнд байршуулдаг. 2021 онд 12 ажлын байр сул гарсаныг байршуулсан.
		7.2	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	Тус газрын албан хаагчид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажилладаг бөгөөд байгууллагын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр байгуулсан бөгөөд ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг байгууллагын цахим хуудасны бидний тухай буланд байршуулсан.
		7.3	Байгууллагын хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд 2021 оны албан хаагчийн ажиллах нөхцөл,

		хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх			<p>нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний төслийг 5 үндсэн зорилтын хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, 2021 оны А/05 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөг 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 1/280 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.</p> <p>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах 2021 оны төлөвлөгөө, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулах ажлын 2021 оны төлөвлөгөө, ГЗБГЗЗГ-аас зохион байгуулах 2021 оны зөвлөгөөн, сургалтын төлөвлөгөөг байгууллагын цахим хуудасны ил тод байдал буланд хүний нөөцийн ил тод байдал цэсэнд байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.</p>
	7.4	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагад цогц чадамжийн хүрээг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтад хүний нөөцийн асуудал хариуцсан болон захиргаа хуулийн асуудал хариуцсан албан хаагчдыг 2021 оны 06 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд хамрагдсан.

						<p>Мөн 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА-нд ТАЗ-ийн 2020 оны 03 тоот “Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай” зөвлөмжөөр төрийн байгууллагуудын хүний нөөцийн томилгоонд шууд болон шууд бус аливаа хэлбэрээр оролцох, нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг хориглосон Төрийн албаны хуулийн заалтыг баримтлан ажиллах чиглэл өгсөн. Мөн Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх ашгийг хөндсөн хууль бус томилгооны зөрчил гарч байгаатай холбогдуулан ТАЗ-ийн 2021 оны Мэдэгдэл, 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01/530 тоот албан бичгээр ирүүлсэн төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх чиглэл, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамжийг тус тус хүргүүлсэн.</p>
		7.5	<p>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;</p>	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	<p>Тус газрын “Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөөг батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, тус газрын даргын 2021 оны А/136 дугаар тушаалаар батлаж үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Дээрх журмыг байгууллагын цахим хуудасны хууль, эрх зүйн акт цэсэнд газрын</p>

						<p>даргын тушаал буланд байршуулсан.</p> <p>Албан хаагчдын 2021 оны 1 дүгээр улирлын тайлангийн явцад ярилцлага хийж, ярилцлагын үнэлгээг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлэсэн.</p> <p>Байгууллагын 64 албан хаагчийн 2021 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу, 10 нэгжийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тус тус үнэлж, үнэлгээг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээ авч, шийдвэрлэж ажилласан.</p>
8	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах	8.1	Тухайн жилийн төсөв мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;	<p>Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын дагуу төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, үнэт цаас, байгууллагатай холбоотой мэдээллийг оруулах албан хаагч нарыг томилон хуулийн хугацаанд мэдээллийг оруулан ажиллаж байна.</p> <p>2021 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2014 оны 384 тоот журамд заасан 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.6, 4.1.9, 4.1.10, 4.1.11,</p>

					4.1.12, 4.1.13, 4.1.16, 4.1.18-д заасан мэдээллийг хугацаанд нь оруулсан.	
		8.2	Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор;	<p>Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын дагуу төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, үнэт цаас, байгууллагатай холбоотой мэдээллийг оруулах албан хаагч нарыг томилон хуулийн хугацаанд мэдээллийг оруулан ажиллаж байна.</p> <p>2021 онд дээрх журамд заасан 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.6, 4.1.9, 4.1.10, 4.1.11, 4.1.12, 4.1.13, 4.1.16, 4.1.18-д заасан мэдээллийг хугацаанд нь оруулан улирал бүр тайланг гарган илгээж байна.</p> <p>2021 онд төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг сар бүр боловсруулан БХБЯ болон Сангийн яаманд хүргүүлэн шаардлагатай байгаа санхүүжилтийн хуваарьт зохицуулалт хийн ажиллаж байна.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ дараах бодлогын баримт бичгүүдийн хүрээнд төлөвлөсөн. Үүнд: “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” улсын хөрөнгө</p>

					<p>оруулалтын хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээний хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэх нийт 23 төсөл арга хэмжээг Сангийн яамны хөрөнгө оруулалтын цахим системд төлөвлөн шивж оруулсан. Үүнээс геодези зураг зүйн 6 төсөл арга хэмжээнд нийт 266.1 тэрбум төгрөг, кадастрын 2 төсөл арга хэмжээ 26,1 тэрбум төгрөг, газрын мониторинг хянан баталгааны 5 төсөлд нийт 10,7 тэрбум төгрөг, төрийн архивын үйл ажиллагаатай холбоотой 3 төсөл арга хэмжээнд 4,9 тэрбум төгрөг, 4-н аймгийн офиссын барилга нийт 6.7 тэрбум төгрөг, агентлагийн барилгад 9,7 тэрбум төгрөг нийт 335.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 23 төсөл арга хэмжээг төлөвлөн БХБЯ /ТЭЗ/-даа хүргүүлсэн.</p>	
		8.3	<p>Дараа жилийн төсвийн төслийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;</p>	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	<p>жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;</p>	<p>2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд санал боловсруулж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн жагсаалтыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын цахим системд шивж оруулсан. Мөн төсвийн төслийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Төсвийн тухай хуульд заасан цагалбарын хүрээнд 2022 оны</p>

						<p>төсвийн хүрээний мэдэгдэлд санал боловсруулан БХБСайдад хүргүүлсэн.</p> <p>2022 оны төсвийн төлөвлөлтийг Засгийн газрын 2021 оны 178 дугаар тогтоолоор баталсан төсвийн хязгаар батлахад баримталсан бодлого чиглэл төв агентлаг, харъяа 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн ГЗБАлбанаас ирүүлсэн саналд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөв, урсгал зарлагын төсвийг тус тус боловсруулан төлөвлөсөн</p> <p>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар тус агентлагийн урсгал зардлыг 3,355.3 сая төгрөг, 21 аймаг нийслэлийн ГЗБА-ний урсгал зардал 13,934.8 сая төгрөг нийт 17,290.2 сая төгрөгөөр батлагдсан. 2021 оны төсвөөс 759.0 сая төгрөгөөр нэмэгдэн батлагдсан. 2022 оны төсвийн хувьд 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн ГЗБА-ны төсөв тусгай зориулалтын шилжүүлэгээс гарч төсвийн хувьд босоо тогтолцоотой болж байна.</p> <p>2022 онд улсын төсөвт 2100.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр, Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод 200 сая төгрөг төвлөрүүлэн зарцуулахаар батлагдсан.</p> <p>2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан урсгал зардлын төсвийн</p>
--	--	--	--	--	--	---

					сар улирлын хуваарийн саналыг боловсруулан БХБЯ болон Сангийн яаманд хүргүүлээд байна.
8.4	Жилийн эцсийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор;	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу 2021 оны 1 дүгээр сарын 1-25-ны өдрүүдэд ГЗБГЗЗГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг БХБЯ-д хуулийн хугацаанд хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	
8.5	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор;	Тус газарт 2021 оны 3 дугаар сарын 5-30-ны өдрүүдэд Үндэсний Аудитын газраас санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийгдэж зөрчилгүй гэсэн дүгнэлт авсан. Дүгнэлтийг шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	
8.6	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт	Байгууллагын тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр оруулан ажиллаж байна.	
8.7	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 01 дүгээр сарын 10-	Байгууллагын 2021 оны Худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд нийт 12 ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийхээр төлөвлөж газрын	

		хуудсанд байрлуулан мэдээлж байх;		ны өдрийн дотор;	даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 тоот тушаалаар батлагдсан. Батлагдсан төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны цахим систем болон шилэн дансанд байршуулж олон нийтэд нийлттэй болгосон. 2021 оны эхний хагас жилийн худалдан авах төлөвлөгөөний тайланг гаргаж, Барилга, хот байгуулалтын яаманд 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 2/1136 тоот албан бичгээр жилийн эцсийн тайланг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1/ 1/2468 тоот албан бичгээр хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгуулагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан.
	8.8	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Сар бүрийн 08-ны дотор	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд сар бүр оруулан мэдээлэн ажиллаж байна.
	8.9	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Сар бүрийн 08-ны дотор	Урсгал төсвөөр хийгдэх худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд туссан 12 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг болон үнэлгээний хороог байгуулж газрын даргын тушаалаар батлуулсан.

			хуудсанд байрлуулан мэдээлж байх;			<p>Бэлчээрийн болон хот суурин газрын мониторингийн үндэсний сүлжээний 500 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, Газрын мониторингийн судалгаа хийж газрын мониторингийн аргачлал боловсруулах, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийг хот байгуулалт, газрын мониторингийн мэдээллийн сантай холбож хот төлөвлөлтийн норм, дүрмийн дагуу шалгалт хийх, БАХ, бэлчээрийн улирлын хил заагийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах модулыг нэмж хөгжүүлэлт хийх, Өндрийн 1-р ангийн сүлжээ байгуулах /55 цэг/, Салбарын системүүдийн мэдээллийн аюулгүй байдалд аудит болон эрсдлийн үнэлгээ хийх, Байгууллагын дата төвийн тоон мэдээлэл дамжуулах сүлжээний өргөтгөл хийх ажлуудын ажлын даалгаврын төслийг хянаж албажуулсан.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 12 ажил бүгд хийгдэж гүйцэтгэлийн тайланг хүлээн авч газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, “Ажил шалгаж хүлээн авсан тухай” дүгнэлт, Гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүнг Архив, мэдээллийн төвд хүлээн авсан тухай актыг тус тус үндэслэн гэрээг дүгнэн</p>
--	--	--	-----------------------------------	--	--	--

						санхүүжилтийг олгох ажлыг зохион байгуулсан. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуульд заасан хугацаанд нь тогтмол байршуулан ажиллаж байна.
8.10	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуульд заасан хугацаанд нь тогтмол байршуулан ажиллаж байна.		
8.11	Худалдан авах ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Бүтэн жилээр	2021 оны худалдан авах ажиллагааны тайланг Барилга, хот байгуулалтын яаманд хагас жилээр гарган хүргүүлсэн. Мөн шилэн дансны цахим хуудсанд сар бүр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг шалгарсан компани, гэрээний үнийн дүн, оролцогч компаний шалгараагүй үндэслэлийн талаарх мэдээллийг тогтмол мэдээллэн ажиллаж байна.		
8.12	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	2021 оны жилийн эцсийн байдлаар Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай		

		урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;			мэдэгдлийг 137 албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг сар бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.
	8.13	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	<i>Тухай бүр</i>	2021 оны жилийн эцсийн байдлаар Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 26 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх эрхийг цахим системд нээж, бүртгэл хөтлөж, баталгаажуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.
	8.14	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Сар бүрийн 08-ны дотор	Байгууллагын батлагдсан орон тоонд ажиллаж буй албан хаагчдын мэдээллийн өөрчлөлтийг сар бүр тогтмол шинэчилсэн.

_ о О о _